



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/Б53

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,  
хэсэгчлэн хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.22 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2019 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, хэсэгчлэн хүчингүй болгох байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар / Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081344

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07  
дугаар сарын 18 -ны өдрийн А/353  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэр,  
чиглэл, хугацаа

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Хужирт тур ХХК	Сувиллын тусламж үйлчилгээ	3 жил
2	“ХЭГИ” ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Есү Энх ХХК	Лабораторийн тусламж үйлчилгээ	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Пролианс ХХК	Ахуйн шавж мэрэгч устгал, ариутгал халдвэргүйтгэлийн бодис импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2019  
оны 07 дугаар сарын 28 -ны  
өдрийн 1353 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
хэсэгчлэн хүчингүй болгох

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Түмэн саруул ХХК	Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох ханган нийлүүлэх
2.	Медклийн ХХК	Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэх, импортлох, худалдах